



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 04 өдөр

Дугаар А/03

Номгон

Сумын 2023 оны “цэргийн бүртгэл”-ийг
явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2022 оны А/738 дугаар захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор сумын 2023 оны цэргийн бүртгэлийг 2023 оны 01 дүгээр сарын 05-13-ны өдрүүдэд зохион байгуулж явуулсугай.

2. Ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Хүрэлсүх (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: Багийн хөгжлийн алба

Б.Мөнгөтулга (Цагдаагийн газрын нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, Цагдаагийн дэд хурандаа)

А.Батхуяг (Цагдаагийн газрын замын цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн хошууч)

Нарийн бичгийн дарга: Г.Бадамханд (Улсын бүртгэгч)

3.Сумын цэргийн бүртгэлээр гаргах бүртгэл, мэдээлэл, судалгааны жагсаалт үйлдэж, төрийн болон албаны нууц хадгалалт, хамгаалалтыг чанд сахиж, ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс нууцын баталгааг авч ажиллахыг Улсын бүртгэгч (Г.Бадамханд)-д үүрэг болгосугай.

4.Цэргийн бүртгэлийн үед нийтийн хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, цэргийн бүртгэлийн байранд ирээгүй иргэнийг эрэн сурвалжилж, бүртгэлд хамруулах бүх талын арга хэмжээ авч ажиллахыг Цагдаагийн газрын нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, Цагдаагийн дэд хурандаа Б.Мөнгөтулга, багийн Засаг дарга нарт даалгасугай.

5.Сумын хэмжээн дэх тээврийн хэрэгслийн судалгааг 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор сумын Засаг даргын Тамгын газарт ирүүлэхийг аймгийн Авто тээврийн төвийн дарга (С.Амармөнх)-д даалгасугай.

6.2005 онд төрсөн 18 нас хүрсэн иргэнийг сумын бүртгэл явуулах байранд өөрийн биеэр заавал ирүүлэхийг багийн Засаг дарга, багийн ажлын албанд үүрэг болгосугай.


7.Цэргийн бүртгэлийг тогтоосон хугацаанд холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж иргэдэд батлан хамгаалах тухай хууль тогтоомжийг сурталчлах, бүртгэл мэдээллийн санд түшиглэн албан байгууллагад ажиллаж байгаа 18-50 насны (эрэгтэй) ажилчин, албан хаагчдыг нэрийн бүртгэлээр явуулах, иргэний мэдээллийг тодотгон баяжилт хийх, шинээр бүртгэгдсэн цэргийн офицер, цэргийн үүрэгтнүүдэд хөтлөгддөг маягт хүснэгтүүдийг үнэн зөв, бүрэн хөтлөж, мэдээг Цэргийн штабт хүргүүлж ажиллахыг нарийн бичгийн дарга Улсын бүртгэгч Г.Бадамхандад үүрэг болгосугай.

8.Цэргийн бүртгэл завсардсан, бүртгэлд хамрагдаагүй иргэдийг Монгол Улсын “Зөрчлийн тухай хууль”-ийн 15, 17 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт заасны дагуу арга хэмжээ авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Бадамханд)-д үүрэг болгосугай.

9.Цэргийн бүртгэлийн зохион байгуулалтын талаар иргэд, цэргийн үүрэгтнүүдэд мэдээлэх, сурталчлах ажилд хариуцлагатай хандаж ажиллахыг Хэвлэл мэдээлэл, олон нийт хариуцсан ажилтан Г.Сувданцэцэг, орон нутгийн телевизийн захирал нарт үүрэг болгосугай.

10.E-Mongolia цахим бүртгэл 2023 оны 01 дүгээр сарын 05-13-ыг хүртэл явагдах тул багийн Засаг дарга нар цахим бүртгэлд хамрагдаж иргэдийн мэдээллийг ажлын хэсэгт жагсаалтаар хүргүүлж ажиллах

11.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Засаг даргын Орлогч (С.Батцэрэн)-д даалгасугай.

ДАРГА  Г.ЭНХБАЯР